



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

### Үнэлгээний баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, Газрын дүрмийн 7.1.1, 7.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын албан хаагчдын 2022 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх үнэлгээний багийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Нийт албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, ажлын тайлантай танилцаж, гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг холбогдох дүрэм, журмын дагуу үнэлж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг 2022 оны 06 дугаар сарын 20-ны дотор танилцуулахыг Үнэлгээний багийн ажлагч (Э.Даваахатан)-д даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ

Газрын даргын 2022 оны 06 дугаар  
сарын 08-ны өдрийн 1/3 дугаар  
тушаалын хавсралт



## ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Багийн ахлагч: Э.Даваахатан  
(Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга)

Гишүүд: Н.Билэгсайхан  
(Худалдаа үйлчилгээний стандартын хэлтсийн  
даргын үүрэг гүйцэтгэгч)

Д.Өлзийсайхан  
(Байгаль орчны стандартын хэлтсийн даргын  
үүрэг гүйцэтгэгч)

О.Оджаргал  
(Стандартын хэрэгжилт, хяналтын хэлтсийн  
даргын үүрэг гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: С.Болдоо  
(Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хяналт,  
шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)